



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1963 оны 7 дугаар
сарын I-ний өдөр

Дугаар 318

Улаанбаатар
ХОТ

Комплекс төхөөрөмжийн импорт
нэгдэл байгуулах тухай.

Гадаад орнуудаас авах зээлийн талаар байгуулагдсан халэлцээрийн үндсэн дээр контракт хийх ажлыг нэгтгэн төвлөрүүлэх, зээлийн хөрөнгийн ашиглалт ба контрактын биелэлтэд тавих хяналт, буртгэл тооцооны ажлыг сайжруулах зорилгоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Гадаад орнуудаас зээлийн хөрөнгөөр авах бүх төрлийн тоноглол төхөөрөмж, материал, машин механизмыг, экспедицийг, техникийн баримт бичгүүд/ гадаад худалдааны шугамаар авах зээлийн бараганаас бусад/, мөн зээлийн хэлэлцээрээр ирүүлэх мэргэжилтэн, гадаад орнуудад хүн явуулж сургах зэрэг асуудлаар өөрийн улсыг төлөөлөн контракт байгуулах, зээлийн ашиглалт, контрактын биелэлтэд хяналт тавих, тайлан буртгэлийн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий „Комплекс төхөөрөмжийн импорт нэгдэл“-ийг аж ахуйн тооцооны үндсэн дээр Улсын Барилга-Эдийн Засгийн Комиссийн харьцанд байгуулж, уул нэгдлийн дарга нь Улсын Барилга-Эдийн Заогийн Комиссийн орлогч дарга байхаар тогтоосугай.

2. Гадаад худалдаа, мөн гадаад худалдааны шугамаар авах зээл, шинжлэх ухаан-техникийн хэлэлцээрээр ирүүлэх мэргэжилтэн, бараа материал, тоноглол төхөөрөмж, машин механизмыг авах, хүн явуулж сургах талаар хийгдэх бүх тооцоо ба контракт байгуулах ажлыг Гадаад Худалдааны Яаманд хариуцисугай.

3. Комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн харьцанд техник туслахийн баазын суурин дээр комплекс төхөөрөмжийн бааз байгуулж,

2.

уг баазад гадаадаас зээлийн хөрөнгөөр төв чиглэлээр ирэх комплекс төхөөрөмжийг шууд хүлээн авч байх журам тогтоосугай.

Зээлээр ирэх комплекс бус төхөөрөмж ба материалыг холбогдох яам, газруудын баазуудад шууд буулгаж байхын гадна, хязгаарын дамжулага баазуудаар ирэх зээлийн бүх комплекс төхөөрөмж, материалыг уул баазууд дээр хүлээн авч байхаар тогтоосугай.

4. Комплекс төхөөрөмжийн импорт нэгдэл байгуулж байгаатай холбогдуулан, Улсын Барилга-Эдийн Засгийн Комиссийн Протоколийн захиалагчийн газрыг татаан буулгаж, түүний уургийг тус нэгдэлд хариуцуулсугай.

5. Комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн байгуулсан контракт ёсоор зээлийн хөрөнгөөр ирэх тоноглол, төхөөрөмж, материалыг аж ахуйн гэрээний үндсэн дээр энэ тогтооны 2-р зүйлд зааснаар сорийн харьяа баазад шууд хүлээн авч, зориулагдсан зүйлд олгох ба тооцоо хийх, зохих мэдээ тайланг тогтоосон журмаар тус нэгдэлд гарган өгч байхыг Гадаад Худалдааны Яам, Хөдөө Аж Ахуйн Яам, Барилга ба Барилгын Материалын Үйлдвэрийн Яам, Сангийн аж ахуйнуудыг удирдах газар, Геологи шинжилгээний газар, Тээвэр, Холбооны Яаманд даалгасугай.

6. Комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн шугамаар харицах бүх уургийг Зөвлөлт Холбоот Улсаас бусад гадаад улсуудад сүүгээ өөрийн худалдааны төлөөлөгчдөд хариуцуулж байхыг Гадаад Худалдааны Яаманд даалгасугай.

Үүнтэй холбогдуулан Польш, Чехословак, Унгар, Ардчилсан Герман улсад суугаа манай худалдааны төлөөлөгчийн аппаратад тус нэгдлийн төлөөлөгчийг /орон тоо нэмэхгүйгээр/ бий болгосугай.

7. Зөвлөлт Холбоот Улсад суугаа Монголын Элчин сайдын Яамны эдийн засгийн зэвлэхийн аппаратыг эдийн засгийн зэвлэхийн товчоо болгох, эдийн засаг, шинийн ухаан-техникийн ажиллагааны хувьд Сайд нарын Зөвлөлийн Эдийн засгийн хамтын ажиллагааны

хороонд, зээний асуудлын хувьд Улсын Барилга-Эдийн Засгийн Комисс тус тус хамааруулан, энэ товчоони ашиглалтад комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн төлөвлөгчийг бий болгосугай.

8. Комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн ажиллагааны зорилтуудыг нөхөхөд зориулсан шинтгэлийн хэмжээг тогтоож сийг Сангийн Яам /и. СОДНОМ/-д даалгасугай.

9. Тус нэгдлийн шугамаар гадаадын ээзи ба худалдаагаар ирэх комплекс төхөөрөмжийг 1964 оны I дүргээр сарын I-нээс эхлэн, захиалагч байгууллагуудад зохих үнээр нь худалдах байх журмыг тогтоож, зээлээр авах комплекс төхөөрөмжийн унийг Улсын Төлөвлөгөөний Комиссоос баталж байсугай.

10. Комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн дурмийг баталж гаргахыг Улсын Барилга-Эдийн Засгийн Комисс /и. МАЙДАР/-т даалгасугай.

II. Улсын Барилга-Эдийн Засгийн Комиссын ерөнхий захиалагчийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан, аж ахуйн тооцоогоор ажилласж байгаа „Алтай” зочид буудал, мэргэжилтийн орон сууцны захиргаа, үйлчилгээний авто баазуудыг нэгтгэж, аж ахуйн тооцоотой мэргэжилтийг үйлчлэх газрыг байгуулсугай.

Б Н И А Улсын Сайд нарын
Зөвлөлийн орлогч дарга

ДУГЭРСҮРЭН

Б Н И А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хөрөг эрхлэх
газрын дарга

БАДАРЧ

Хуулбар танц. Тогтоолын цагийн
эрхлэлийн



6. Адоғийн
ДАГВАДОРЖ